



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

2025 оны 06 сарын 23 өдөр

Дугаар E/05

Төрийн ордон, Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
ДАШЗЭГВИЙН АМАРБАЯСГАЛАН ТАНАА

Элчин сайд нарыг эгүүлэн татах
асуудлаар зөвшилцөх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн:

1. Монгол Улсаас Тайландын Хаант Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Амарсанаагийн Төмөр,
2. Монгол Улсаас Бүгд Найрамдах Арчилсан Лаос Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Жамсрангийн Бямбасүрэн нарыг тус тус эгүүлэн татах асуудлыг зөвшилцөхөөр хүргүүлж байна.

Холбогдох материалыг хавсаргав.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ



УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ

2025000022



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ
УХНААГИЙН ХҮРЭЛСҮХ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

2025. 06. 10 № ЗГ-1/71
танай _____-ны № _____-т

Санал өргөн мэдүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсаас Тайландын Хаант Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд А.Төмөр, Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Ж.Бямбасүрэн нарыг тус тус эгүүлэн татах тухай саналыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу өргөн мэдүүлж байна.

Холбогдох материалыг хавсаргав.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
САЙДЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



 Я.ОЮУН-ЭРДЭНЭ

000254003711

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 26 дугаар хуралдааны тэмдэглэлд:

“26.ХЭЛЭЛЦСЭН нь: Монгол Улсаас гадаадын зарим улсад суугаа Элчин сайд нарыг эгүүлэн татах тухай

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсаас Тайландын Хаант Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд А.Төмөр, Монгол Улсаас Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Ж.Бямбасүрэн нарыг тус тус эгүүлэн татах саналыг хэлэлцэн дэмжиж, энэ тухай саналыг Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР